

ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААНД ТҮРҮҮЛЭЭД,

ОЮУ ТОЛГОЙ
УУРХАЙН
ЦОГЦОЛБОРООР

АЯЛ
ДААРАЙ

Та бүхэн манай компаниас зохион байгуулж буй **“Аюулаас ангид амьдарцгаая”** гэрэл зургийн уралдаанд идэвхтэй оролцож, дэлхийд тэргүүлэгч Монголын уул уурхайн Оюу Толгой компанийн үйл ажиллагаатай танилцах боломж нээлттэй байна.

Үүний тулд Фэйсбүүк дэх Оюу Толгой ХХК-ийн хуудаст “лайк” дарж, таны гэр, ажлын байр болон гудамж талбайд байгаа аюул, эрсдэл дагуулж болох зүйлсийг танин илрүүлж, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан гэрэл зургийг бидэнд илгээгээрэй.

Та бүхэн энэ уралдаанд 2 гэрэл зургаар оролцоно.

1. Эхнийх нь таны эргэн тойронд буй ямар нэгэн аюултай зүйлсийг тодорхойлсон гэрэл зураг байна. Мөн тухайн аюулыг 140 тэмдэгтэд багтаан тайлбарлана.
2. Хоёр дахь нь тухайн аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор арга хэмжээ авсан гэрэл зураг байна. Авсан арга хэмжээгээ мөн 140 тэмдэгтэд багтаан тайлбарлана. Мөн таны зураг гэдгийг нотлохын тулд аюулгүй болгосон зүйлийнхээ хажууд та зургаа авахуулсан байх шаардлагатайг анхаараарай.

Хэрхэн оролцох вэ?

Та 2014 оны 4 дүгээр сарын 15-ны 9:00 цагаас 4 дүгээр сарын 30-ны 18:00 цагийн хооронд **“Аюулаас ангид амьдарцгаая”** сэдэвт гэрэл зургуудаа online@ot.mn руу илгээгээрэй.

